



БАТЛАВ.
“ДДЦС” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ
М.ЖАРГАЛСАЙХАН
2021 оны 05 сарын 25 өдөр



БАТЛАВ.
“ӨСӨХ САНСАР” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ
Б.ДАМДИНСҮРЭН
2021 оны 05 сарын 25 өдөр

ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

№85/21

2021 он 05 сар 25 өдөр

Дархан-Уул аймаг.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Нэг талаас “Өсөх сансар” ХХК /цаашид “худалдагч” гэх/-г төлөөлж захирал Б.Дамдинсүрэн, нөгөө талаас “ДДЦС” ТӨХКомпани /цаашид “худалдан авагч” гэх/-ийг төлөөлж хангамж үйлчилгээний хэлтсийн дарга Э.Алтантулга нар Монгол улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”–ийн 40.1, Иргэний хуулийн 243-р зүйл, Үнэлгээний хорооны 2021 оны 05-р сарын 13-ны өдрийн зөвлөмжийг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

1.2.Худалдагч нь худалдан авагчийн тендерийн материалд заасан техникийн тодорхойлолтод заасан чанарын болон эрүүл ахуйн стандартын шаардлага хангасан, нийт 22,235 кг үхэр, хонь, адууны махыг /цаашид “бараа” гэх/ худалдан авагчид нийлүүлнэ.

1.3.Энэхүү гэрээг хоёр тал удирдлага болгох ба гэрээ нь батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчлэх бөгөөд төлбөр тооцоог хийж дууссан өдрөөр дуусгавар болно.

Хоёр. Гэрээний хугацаа, чанарын баталгаа

2.1.Барааг нийлүүлэх гэрээний хугацааг хоёр тал харилцан тохиролцож тогтоох бөгөөд хуанлийн тооллыг удирдлага болгоно.

2.2.Гэрээт барааг 2021 оны 05-р сарын 25-ны өдрөөс эхлэн 2021 оны 12-р сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд нийлүүлнэ.

2.3. Гэрээгээр нийлүүлж буй мах нь хүнсний эрүүл ахуйн шаардлага хангасан, лабораторийн шинжилгээнд хамрагдсан байна.

2.4.Гэрээгээр нийлүүлэх махыг худалдан авагчийн жингээр хэмжиж худалдагч талын жинтэй харьцуулж авна. Жингийн зөрүү гарвал хоёр талын жингийн дунджаар авна. Их хэмжээний зөрүүг гуравдагч этгээдийн баталгаажсан жингээр хэмжиж шийдвэрлэнэ.

Гурав. Гэрээний үнэ, төлбөр тооцоо

3.1.Гэрээгээр техникийн тодорхойлолт шаардлага хангасан хавсралтад заасан 2 төрлийн 22,235 кг хонь, адуу, үхрийн махыг нийт 188,272,300.00 /нэг зуун наян найман сая хоёр зуун далан хоёр мянга гурван зуу/-н төгрөгөөр нийлүүлнэ. Гэрээний үнийн дүнд бүх төрлийн татвар, тээврийн зардал болон бусад бүх зардал тооцсон болно.

3.2. Гэрээ хэрэгжих хугацаанд гэрээний нэгж үнэд тохируулга хийхгүй.

3.3.Гэрээний төлбөрийг гэрээний хавсралтад заасан хуваарийн дагуу мах нийлүүлэгдсэнээс хойш 30 хоногт багтаан худалдагчийн Хас банкны 5003815215

дугаартай дансанд шилжүүлнэ.

3.4. Гэрээгээр нийлүүлэх барааг нийлүүлж дуусахад орлогын баримт, тооцоо нийлсэн актыг үндэслэн гэрээг дүгнэж акт баталгаажуулснаас хойш 30 хоногт багтаан үлдэгдэл төлбөрийг худалдагчийн дансанд шилжүүлнэ.

3.3. Нийлүүлсэн барааны тээвэрлэлтийг худалдагч тал хариуцна. Барааг хүнсний зориулалтын автомашинаар тээвэрлэнэ.

Дөрөв. Худалдагчийн үүрэг

4.1. Худалдан авагчийн захиалгын дагуу барааг гэрээнд заасан хугацаанд худалдан авагчид хоёр талын төлөөллийг байлцуулан үзлэг хийлгэж акт үйлдэн баталгаажуулж санхүүгийн баримтын хамт хүлээлгэн өгнө.

4.2. Худалдан авагчид бараа нийлүүлэх тухай бүр нийлүүлсэн барааны чанарын болон гарал үүслийн гэрчилгээ, эрүүл ахуйн шинжилгээний бичиг, МХУ-ын байцаагчийн дүгнэлт зэрэг шаардлагатай дагалдах бичиг баримтыг барааны хамт хүлээлгэн өгнө.

4.3. Нийлүүлсэн бараа нь чанарын доголдолтой эсвэл эрүүл ахуйн шаардлага хангаагүй тохиолдолд доголдлыг арилгах үүрэгтэй.

4.4. Худалдагч барааг эцсийн цэг хүртэл тээвэрлэх явцад бохирдох, муудах, чанараа алдахаас урьдчилан сэргийлэх баглаа боодол хийж тээвэрлэнэ.

4.5. Худалдагч тал санхүүгийн баримт бүрдүүлээгүй, НӨАТ-ын шивэлтийг хийгээгүй хугацаа алдсан тохиолдолд худалдан авагч тал хариуцлага хүлээхгүй.

4.6. Худалдагчийн нийлүүлэх бараа нь үхэр, хонины махны ерөнхий шаардлага MNS 4080:1988 стандартын шаардлага хангасан, шинэ, сайтар цэвэрлэгдсэн, гадны элдэв бохирдол /үс ноос, шороо, бензин тосны үнэр шингээгүй/-гүй, 1-р зэргийн мах нийлүүлнэ.

4.7. Гэрээ хэрэгжих хугацаанд барааг бэлтгэн нийлүүлж байгаа өөрийн байр болон хадгалах агуулах, мах бэлтгэж байгаа үйл явцад чанарын болон стандартын шаардлага хэрхэн мөрдөгдөж байгаатай танилцаж дүгнэх боломжоор худалдан авагчийг хангана.

4.8. Гэрээ байгуулахад гэрээний үнийн дүнгийн 5%-тай тэнцэх 9,413,615.00 төгрөгийн гэрээний гүйцэтгэлийн баталгаа гаргаж ирүүлнэ. Гэрээ гүйцэтгэгдэхгүй тохиолдолд үл маргалдах журмаар худалдан авагчид шилжүүлнэ.

4.9. Барааг нийлүүлсэн өдрөөс 24 цаг өнгөрснөөс хойш худалдан авагчийн буруугаас, барааг буруу хадгалж хамгаалснаас нийлүүлсэн бараанд доголдол үүсвэл худалдагч тал хариуцлага хүлээхгүй.

Тав. Худалдан авагчийн үүрэг

5.1. Худалдан авагч нь барааг хүлээн авахдаа чанарын шаардлага хангаж байгаа эсэхийг шалгаж хүлээн авна. Шаардлага хангахгүй тохиолдолд буцаах эрхтэй.

5.2. Худалдагчийн нийлүүлсэн барааг шалгаж хүлээж авах явцад илэрсэн доголдлыг худалдагч талд мэдэгдэж шийдвэрлэнэ.

5.3. Худалдан авсан барааны төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөх үүрэгтэй.

5.4. Гэрээ хэрэгжих хугацаанд худалдагчийн мах хадгалах агуулах, мах бэлтгэж байгаа байрны стандарт шаардлага хэрхэн мөрдөгдөж байгаатай танилцаж шалгах хуудсаар дүгнэж шаардлага хангахгүй зөрчилтэй байгаа асуудлыг шийдвэрлэнэ.

5.5. Гэрээний хавсралтад заасан бараа нийлүүлэх хуваарь, тоо хэмжээнд өөрчлөлт оруулах тохиолдолд 7 хоногоос доошгүй хугацаанд худалдагч талд мэдэгдэнэ.

Зургаа. Талуудын хүлээх хариуцлага

6.1. Худалдагчийн буруугаас гэрээгээр нийлүүлэх барааг хугацаанд нь нийлүүлээгүй тохиолдолд нийлүүлээгүй барааны үнийн дүнгийн 0.1%-ийн алдангийг хоног тутамд үл маргалдах журмаар төлнө. Алдангийн нийт хэмжээ төлөгдөөгүй үнийн дүнгийн 10%-аас хэтэрч болохгүй.

6.2. Худалдагчийн буруугаас чанарын шаардлага хангаагүй доголдолтой бараа нийлүүлсэн тохиолдолд шалтгаалж гарсан хохирлыг бүрэн хариуцах ба доголдолтой барааны үнийн дүнгийн 0,1%-ийн торгууль төлнө.

6.3. Худалдан авагч тал гэрээний төлбөрийг гэрээнд заасан хугацаанд нь төлөөгүй тохиолдолд төлөөгүй үнийн дүнгийн 0.1%-ийн алдангийг хоног тутам тооцож худалдагчид төлнө. Алдангийн нийт хэмжээ төлөгдөөгүй үнийн дүнгийн 10%-аас хэтэрч болохгүй.

Долоо. Давагдашгүй хүчин зүйл

7.1. Давагдашгүй хүчин зүйл (үер, гал түймэр, газар хөдлөлт, халдварт өвчний тархалт, зэвсэгт мөргөлдөөн, террорист үйлдэл, иргэдийн үймээн, ажил хаялт, төрийн шийдвэр оролцоо г.м)-ийн нөхцөл байдлын шууд болон шууд бус үйлчлэлийн улмаас талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй тохиолдолд тухайн нөхцөл байдлыг арилгах хүртэл хойшлуулж болно.

7.2. Гэрээний үүргийг биелүүлэхэд саад болох давагдашгүй хүчин зүйлийн нөхцөл байдал үүссэн, дууссан тухай талууд нэн даруй нэг нэгэндээ бичгээр мэдэгдэж хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

Найм. Маргаан шийдвэрлэх

8.1. Гэрээтэй холбоотой маргааныг талуудын харилцан тохиролцох замаар шийдвэрлэнэ.

8.2. Талууд харилцан тохиролцоонд хүрч чадахгүй бол Монгол улсын хууль тогтоомжийн дагуу маргааныг шүүх, арбитрын байгууллагаар шийдвэрлүүлнэ.

Ес. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, цуцлах

9.1. Гэрээнд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж талуудын гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

9.2. Холбогдох хууль тогтоомжид заасан үндэслэлээр 2 тал харилцан тохиролцож гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж болно.

Арав. Бусад

10.1. Энэхүү гэрээг 3 хувь үйлдэж худалдан авагч тал 2 хувийг, худалдагч тал нэг хувийг хадгална.

10.2. Гэрээний хавсралт болон нэмэлт өөрчлөлт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.

Арван нэг. Талуудын хаяг

Худалдан авагчийн хаяг:

Дархан-Уул аймаг

13-р баг.

Худалдагчийн хаяг:

Дархан-Уул аймаг, Дархан сум







10-р баг, 24-р хороолол


Барилгачдын өргөн чөлөө 3-302 тоот

Холбоо барих утас:
99069112, 99995993, 70373021

Холбоо барих утас:
99043308, 99976512

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Худалдан авагчийг төлөөлж:
Ерөнхий инженер
 Б.Хаш-Эрдэнэ
СБХ-ийн дарга
 Ц.Ууганбаяр
ХҮХ-ийн дарга
 Э.Алтантулга
СБХ-ийн ня-бо
 Ч.Болормаа
Хуульч
 Д.Сэргэлэн
Гэрээ эрх зүйн мэргэжилтэн
 Г.Оюунбилэг

Худалдагчийг төлөөлж:
“Өсөх сансар” ХХК-ийн
ня-бо  Д.Батжаргал



85/21 дугаартай гэрээний хавсралт

Гэрээгээр нийлүүлэх барааны нэр төрөл, тоо хэмжээ, үнэ

№	Нэр төрөл	Мах нийлүүлэх огноо								Дүн
		2021.06.10	2021.07.08	2021.08.08	2021.09.08	2021.10.08	2021.11.08			
1	Үхрийн мах /кг/	1,495	1,495	1,495	1,495	1,495	1,495	1,495	7,114.00	14,589
	Нэгж үнэ /төг/	10,500.00	10,000.00	8,500.00	8,500.00	8,500.00	8,500.00	8,500.00	8,500.00	
	Дүн /төг/	15,697,500	14,950,000	12,707,500	12,707,500	12,707,500	12,707,500	12,707,500	60,469,000	129,239,000
2	Хонины мах /кг/	805	805	805	805	805	805	805	3,221	7,246
	Нэгж үнэ /төг/	9,000	8,500	7,500	7,500	7,500	7,500	7,500	7,300	47,300
	Дүн /төг/	7,245,000	6,842,500	6,037,500	6,037,500	6,037,500	6,037,500	6,037,500	23,513,300	55,713,300
3	Адууны мах /кг/							400		400
	Нэгж үнэ /төг/							8,300		8,300
	Дүн /төг/							3,320,000		3,320,000
	Дүн /кг/	2,300	2,300	2,300	2,300	2,300	2,300	2,700	10,335	22,235
	Дүн /төг/	22,942,500.00	21,792,500.00	18,745,000.00	18,745,000.00	18,745,000.00	18,745,000.00	22,065,000.00	83,982,300.00	188,272,300.00